



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 69

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Цагаандэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 84,758,152,88 /наян дөрвөн сая долоон зуун тавин найман мянга нэг зуун тавин хоёр төгрөг наян найман мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй, 5,635,149,20 /таван сая зургаан зуун гучин таван мянга нэг зуун дөчин есөн мөнгө хорин төгрөг/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий барилга байгууламжийг Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Цагаандэлгэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч (Д.Сарантуяа), Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Мөнх-Оргил) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Шилжүүлэх хөрөнгийг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэн, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 12 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



СОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн
69 дугаар тогтоолын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Цэцэрлэгийн барилга	2008-11-10	Хүүхэд	1	83,410,904.88	5,560,727.04	77,850,177.84	Цагаандэлгэр сум ЗДТГ
2	Хайлаас мод	2018-12-29	Ширхэг	1	39,932.00	0.00	39,932.00	Цагаандэлгэр сум ЗДТГ
3	Бетон хучилттай явган зам	2018-12-30	м2		220,765.00	35,318.40	185,446.60	Цагаандэлгэр сум ЗДТГ
4	Цэцэрлэгийн хашаа	2010-09-29	м		586,561.42	39,104.16	547,457.26	Цагаандэлгэр сум ЗДТГ
Нийт дүн				2	84,258,163.30 /наян дөрвөн сая хоёр тавин найман мянга нэг зуун жаран гурван төгрөг гучин мөнгө/ төгрөг	5,635,149.60 /таван сая зургаан зуун гучин таван мянга нэг зуун дөчин есөн төгрөг жаран мөнгө/ төгрөг	78,623,013.70 /далан найман сая зургаан зуун хорин гурван мянга арван гурван төгрөг далан мөнгө/ төгрөг	